

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Нямхүүгийн Дэжид	Дугаар	L013
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Сүхбаатар дүүрэг
Төрсөн газар	Сэлэнгэ аймгийн Хушаат сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	Тэтгэвэрт		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Амарбаясгалант хийд, Дарь Эхийн хийд	Сүм хийдийн дугаар	СЭББ 049, СЭСА 043
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 26	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд
Сайхан сумын Дара эх ламын хийд

Одоо өнөөдөр Дархан хотод байгаа Хараагийн Дарь Эхийн хийдэд бол манайх ойрхон байсан. Мөн Өндөр гэгээний хийд ч гэнэ, Амар хийд ч гэнэ тэнд мөн манайх их нутаглаж зузаж байсан. Дарь Эхийн хийд тийм ч жаахан газар биш. Тэнд би бол их ойрхон. Тэндэх улсыг мэддэг байсан юм. Дарь Эхийн хийд олон ламтай, олон дацантай байсан юм.

Амарбаясгалант хийд дээр үедээ Хушаатын нутагт байсан. Одоо бол Баруунбүрэн сумын нутаг. Бүрэнхаан гэж том онгон дархан уул бий. Баруунтаа ганц суврагатай хадаг болсон уул байсан юм. Одоо түүнийг Есөн суврагат гэж нэрлэсэн байна лээ. Амарбаясгалант хийдийг анхлан байгуулахад ерөөсөө бүтэхгүй талтай байсан. Тэгэхээр нь засаг амбан гэдгийн тушаалаар бүтээсэн юм уу. Бүтэхгүй байгаад л байсан. Нэг л өдөр бүтлээ гэж хэлсэн. Тэгээд л бүтсэн. Амарбаясгалант хийд

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

зарлигаар бүтсэн гэдэг түүхтэй байдаг. Амар, Баясгалан гэдэг хоёр жижигхэн хүүхэд, банди юм даа тэр үедээ. Тэр хоёрыг гүйж явахаар нь барьж аваад Цогчэн дуганын үүдэнд хоёр том улаан багана бий. Тэнд тэр хоёрыг нүгэл буян ч гэж бодолгүй амьдаар нь булаад шавардчихсан юм гэнэ лээ. Тэгсэн тэр нутгийн Дамдиндоржийнх гэдэг айлаас хоёх ихэр хүү төрөхөд за би улаан багананд булаатай байгаа тэр хоёр хүүхдийн дурсгалд зориулж Амар, Баясгалан гэж нэрлэлээ гэж хэлж байсан.

Лам нарын тоо нэг мянга ч үгүй байх. Тэрнээс л илүү байсан байх.

Махранз гэж үүдэн дээрээ маягтай том бурхан бий. Баруун талд хоёр, зүүн талд хоёр байдаг байсан. Тэр устгагдаагүй үлдсэн байгаа юм. Орох хаалганы хоёр талд өөртөө таарсан дугантай гартаа дайсныг дарах зэвсэг барьсан, хөл дороо шулмасыг даран устгаж байгаа байдал нь гээд шувуу, могойн хошуутай, томоо гуталтай түүгээрээ гишгэчихсэн тийм бурхан байдаг юм. Хүүхэд айгаад ордоггүй байсан юм.

Устгалын үед тэрийг устгах гэж цавчаад ч дийлээгүй. Нэг тийм паалантай юм шиг, одооны цементнээс хатуу, гөлчийсэн эдээр хийсэн байдаг.

Гол зуу гэдэг сүмд суугаа хүний өндөртэй олон том гуулин бурханууд байдаг байсан. Сүүлд нь хоёр хуваагаад таслалчихсан нэг бурханы цээж нь үлдсэн байсныг харж байсан юм би.

Амар хийдэд их өргөн цам зуны дунд сарын 29-нд гарна. Цам нь Хараагийн дарь эхийн хийдээс зарим нь илүү сайхан байсан. Майдар эргэнэ. Цам гарахад ойр хавийн амьтад тоймгүй их, Ийвэнгийн гол гэдэг дээр асар майхан, жодгор, овоохой ч байж магадгүй бариад цуглана даа. Ийвэнгийн гол гэдэг их сайхан урт гол байгаа, дээд талаасаа Халуужингийн даваа, Бүрэнхаан гэж бий. Ер нь орон нутаг нь Бурханы орон гэж юу байдаг юм бол доо. Ой мод, ус, булан тохой бүр нь булаг шандтай, юм болгон байдаг. Зун гэхэд л ялаа батгана байдаггүй. Дээд талд нь Сэндэнгийн Цагаан нуур гэж байдаг. Жимсний орон. Ийм л сайхан орон нутаг юм.

Арван таван лангийн үнэтэй

Амарбаясгалант хийд зарлигаар бүтсэн гэдэг түүхээрээ ер нь л их сайхан орон байсан. Тээр хол Хүжийн даваа гэдгээр даваад орж ирэхээр сүмийн орой алтаар барьсан юм шиг гялалзаж байдаг. Тэрний дээр алтан ганжир гэж их том юм байгаа. За тэгээд арслан барсын цувсан дүрс нь дандаа алт биш юм гэхэд гууль байсан юм байлгүй нэг их сайхан гялалзаж байдаг байсан. Сүүлд нь тэгээд устгагдсан юм. Хийдийг устгасан тэр жил ойндоо хүрээгүй байсан миний хүү одоо энэ жил /2007/ 72-той нас барлаа./1935он/ Би бол хийд үүсэн байгуулагдах үеийг нь мэдэхгүй. Харин тэр устаж байсан үеийг нь үзэж харж байсан юм. Тэр жил таван аймаг нийлж Бургалтайн Цагаан овоо гэдэг газарт мундаг том наадам хийж байсан. Тэгэхэд тэрэнд манайхан очиж байв. Сэлэнгийнхэн гэхэд хуй морь уясан улс очно. Цаанаасаа Булган, Дайчин вангийнхан гэж нэр их түрэмгий улсууд нэг аймаг сум ирж байсан юм. Би Сэлэнгийнхэнтэйгээ очиж байлаа. Наадамд яваад дайраад гарахад тэр юм хэвээрээ байсан. Цамгүй үе таарсан. Зүгээр орж мөргөлөө хийгээд дайраад гарч байсан. Намар нь 8-р сарын 20 хэдэн болсон уу үгүй юу, лам нарыг чинь учиргүй бариад, бэржээнхээр бүтээсэн том машинаар

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэлэнгэ рүү ачаад давхиад байдаг, давхиад байдаг, тэгсээр байгаад ой мод биш юм болохоор хүн олон ч гэсэн барагдаж л байгаа болтой байсан. Тэгж нэг намар бараг л хүн бурхан хоёр бол дууссан даа. Содном да гэсгүй, Дамдин унзад, Минжүүр шунлайв гээд настай мундаг мундаг том том цагаан лам нар байдаг байсан. Тэд бүгдээрээ ачигдсан. Тэр бэржээхэн дор. Манай сумын эрх мэдэлтэнгүүдийг аймгаас ирсэн улсууд авч явдаг байсан юм. Манай өвгөн сургуулийн захирал байсан. Бас аваад явсан. Чи одоо лам нарыг барьж байгаа юм уу гэсэн. Бариад байхдаа ч би биш, яваагүй дээ ч биш, явсан шүү дээ гэж бүдүүн тоймоор надад тэгж ярьж байсан. Сэлэнгийн дотоод явдлынхан гээд учиргүй их хүмүүс ирнэ. Хийдийн сүм, дуганыг байтуу гэдэг материалаар барьсан учраас маш бөх. Одоо ч байж л байгаа.

Амар хийдэд Гэгээн сан гэж байсан. Жас юм.

Сүүлийн үед нь Содном хурц байхгүй нас барсан байсан. Мэргэн Баажав, Дамдин унзад гэдэг хоёр хүн л их дээгүүр лам нар байсан. Содном хурц гэдэг хүн бол хувилгаан биш. Гэхдээ Халхад гүйцэгдэхгүй ухаантай хүн байсан гэж байгаа. Баахан гамин Сээрийн даваа гэдгээр даваад Өндөр гэгээний хийдийг очиж баллах гээд ирж гэнэ. Лам нар нь хэрмэн дотроо л байж гэнэ. Содном хурц да гэсгүй байхдаа бэрээгээ бариад тэр их олон гамингийн урдаас очсон. Махранзын тэнд Улаан шөрөг гэж байгаа юм. Тэрэн дотор морьтой хүн хамаагүй ч ордоггүй. Улаан шөрөг рүү бөөн гамин орох гээд явж байхад Содном хурц урдаас нь гараад л бэрээгээрээ газар шаагаад “Байз, хүлээж бай” гээд хашгирахад гамин хоёр тийшээ ярагдаад зогссон. Тэгээд орж чадаагүй явсан гэсэн. Хурц гуайг бар шинжийн хүн гэж байсан юм гэнэ лээ. Минжүүр шунлайв гэж алдартай эмч байсан. Сэргэн Баажав гэж мэргэч, төлгөч хүн байсан. Дамдин унзад гэж онцгой дуутай хүн байсан. Халхад Дамдин унзад шиг дуугардаг хүн байгаагүй юм гэнэ лээ. Намайг мэдэхийн настай сахалтай хүн байсан. Дамдин унзадыг хуралдаа номоо эхлээд мандалаа барихад мандалын арвай нь доргиж асгаад тогтохгүй байдаг байсан гэдэг. Бороо хариулдаг Хар эрхт ловон гэдэг хүн байсан. Чухал ажлын үед бороо оруулдаггүй байсан гэсэн. Содном хурц гэдэг бол их чадалтай. Нэг айлын их олон шар хүүхэд байсан юм гэнэ лээ. Дүү нар нь гээд Цэрэнлхам, Цэрмаа гээд хэзээ хойно жижигхэн жижигхэн хөгшин шар авгай нар байсан. Хурц гуайгаас хойно. Хурц гуай дүү нартаа эрдэм мэдлэг олгосон. Тоо, монгол бичиг, сампин мэднэ. Цэрмаа гуайн суусан нөхөр нь нэг гуншаа хүн байсан. Очирхүү хэлгий хэлээд гуншаад байхад Цэрмаа гуай сампинд хийгээд л болгоод байх юм даа гэж манайхан хэлдэг байсан юм. Сүүлд нь бүр хөгшин болсон хойно нь мал бааз дээр аваачаад нягтлан хийлгэж байсан. Хурц гуайн дүү нар гэж ийм хүмүүс байсан юм. Дүү нартаа юм болгоныг зааж өгсөн байгаа юм. Содном хурц гуай Ар тойлов гэдэг газрын унаган хүн гэж байсан. Ар тойловт ч нэг жалгын дацан байсан. Ер жалгын дацангүй газар гэж байгаагүй.

Амар хийд гадуураа их бөх бат хэрмэн хашаатай. Нураах гээд ч нураагүй. Засах гээд ч засаагүй. Голдоо Цогчэн дуганатай. Тэндээ Өндөр гэгээний шарилтай. Суврага нэг их олон байгаагүй. Хийдийн баруун талд нэг, ерөөд нэг тааруухан, Бурхантын аманд нэг, хоёр хаалганы буланд хоёр байлуу. Тэгээд л боллоо. Өндөр гэгээний хийдийг хааж эхлээд Далчиддорж гэдэг эмч бас нэг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

өвгөнтэй манаа тавиад тэндээс хүн юу ч авахын аргагүй байсан. Тэр хоёр баригдчихмаар тушаалтай улс биш. Тэнд их удсан. Гол зуу сүмд хадгаар холбогдчихсон юм шиг босоо хүний дайтай бурхан дүүрэн байдаг байсан. Хэзээ хойно очиход тасархай гуулин бурхан хэд байсан. Өөр юм юу ч байгаагүй. Их ч баян. Тэр их олон том бурханыг ачааны машинд арзайтал сарзайтал ачаад. Манайхан Хиагт зам гэдгийн хажууд зусаад намарждаг юм. Хушаат гэдэг чинь Амар хийд дээрээс Сээрийн даваа гэдгээр давж хүрч ирдэг. Хушаатын замаар яваад Амар хийд дээрээс Алтанбулаг руу Хиагт замаар явна. Урдаар лам зөөгөөд л байсан, зөөгөөд л байсан. Лам нь дуусаад бурхан зөөсөн. Намартаа зөөсөн. Тэгээд тэр их бурханыг хийх газар байхгүй Засангийн хашаанд асгаад байсан гэсэн. Тэр бурхад чинь хөндий. Ёроол нь таглаатай. Сөхөхөөр шүншигэнд нь есөн эрдэнэ байна. Шүншигний алтны өөдөс, сувд цементэн шалан дээр асгараад сувд нь гулгаад гишгэж болохгүй байлаа гэж сонсогдож байсан. Сүүлд нь тэр бурхануудыг хойш нь давуулсан. Тэгж сувд асгарч байсныг мэдэх хүн нэг л байсан. Одоо байхгүй болсон. Бужгар гэж жүжигчин бий. Тэрний аав улаан Санжаа гэдэг хүн Сэлэнгийн Засангийн дарга байсан. Бужгар нэг сонсож байсан байж магадгүй. Мал хураагаад.Цагааннуур сум цахартай. Их баян. Тэндхийн малыг хураагаад туухад түрүүч нь Алтанбулаг орж байхад сүүлч нь нутгаасаа хөдөлж байсан гэж яригддаг. Тоймгүй их мал хураасан. Хаашаа орсон юм. Олны идэш болоод л дууссан байх даа. Барагдах юм амархан. Бадраах юм хэцүү гэсэн үгтэй хойно.

Манайх Амарбаясгалант хийд рүү Оройн ерөөл, Эрдэнийн Ганжуурыг жилдээ нэг уншуулах гэж мөн Мандал өргүүлэх гэж явдаг байсан. Өргөлдөө нэг морь уячихаад явна. Манайд уургын хүрэн гэж сайн морь байсан. Тэрийгээ уясан. Өндөр гэгээнд Мандал өргөж байгаа юм. Юугаа ч өргөсөн хамаагүй гэсэн. Тэгсэн хүн хүрэн морийг чинь жасынхан хонинд унаад нурууг нь авчихсан байгаа даа гэж хэлж байсан. Аав яавал яаг, яахав яахав гэж байсан.

Цагаан сарын 14-ний ерөөлөөр хотоос ч хүн очно. Золгоод өнгөрснөөс хойш 14 хоног хуралтай. Хүн өнгөрөхөд бодийг нь хөтлүүлнэ гэж мориныхоо зуузайнаас хадаг уяаад хүнтэй дуугарахгүй номоо уншуулах юмаа сүжигтэй ламдаа аваачиж өгнө. Дарь эхийн хийд дээр ч бодь ерөөдөг хүн байсан. Амар хийдэд 10 сарын 29-нд цам гарна. Одоогийнхоор бол зуны сар буюу 8-р сар. Цам өдөржин гарна. Би 12 настай байхдаа аав ээжтэйгээ Эрдэнэзуу орсон. Манай аав дандаа бие нь өвддөг. Тэгээд мөргөл хий гэсэн. Морин тэргээр тухтайхан явахад Хушаатаас 6 хонож очсон. Ганжуур эргэхэд дагаад сүжиглэж болно. Судраа үүрээд явсан ч болно. Хайлан хурна. Анчин байгаад лам болсон хүн хайланд хурж байсан. Ангаа бодоод л сууж байсан. Би нэг намрын хөөсөн цаснаар сууринд суугаад байж байсан чинь нэг муу чоно намайг хараад гэснээ хээ гээд больж байсан юм гэсэн. Хайланд сууж байгаа лам ан бодох байтугай амьдрал ч бодож болохгүй. Нүгнээ сахих бол захаас аван. Хаа сайгүй.

Хөдөө бас жижиг жижиг дуган дацангууд байсан. Номтын дуган, Шивэртийн дуган. Тэд бас ламтай, хуралтай. Сүүлд нь тэднийг чинь бариад, хөдөөний лам гэж гололгүй ачаад дуусчихсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Манай аавын эгчийнх нэг ламтай айл байсан. Галсанжамц гавжийнх гэж. Манай багш. Тэр хүнийг баригдаж явчихаад байсныг орон гэрийнхэнтэй нь төрөл садны холбоотой байсны хувьд мэднэ.

Буурын Данзан эмч гэж Сэлэнгэд алдартай сайн эмч байсан. Мал хөрөнгөтэй, ах дүүтэй. Харин тэр хүнийг бариагүй байсан. Сүүлд нь домог ярианд Сүхбаатарын ухаа хонгор морийг Данзан эмч ухаа хонгор адуунаасаа өгч залгуулсан юм гэж ярьдаг. Энийг би худлаа ч үгүй болов уу гэж боддог юм. Буурын гол гэдэг чинь Алтанбулаг, сүүлдээ Сэлэнгэ аймаг гэдэг болсны энүүхэнд байдаг гол юм. Данзан эмчийнх тэнд ганцаараа нутагладаг. Буурын Данзан эмчийнх гэж нэрлэгдсэн хүн байсан юм. Манай аав өвчтэй. Тэгээд хос морьтой яваад л тэндээс төвд эм залж ирдэг байсан юм. Тийм болохоор би сайн мэддэг байсан юм.

Дарь эхийн хийдийн эзэн нь Хараагийн дарь эх лам байсан. Сүүлд нь Ёнзон хамба гэдэг хүн байсан. Сүүлд нь Дандар хамба гэдэг хүн байсан. Дандар хамба баригдаад явсан. Тэгээд устгал нь эхэлсэн. Байнгын хуралтай, цамтай, майдартай байсан.

Хүүр чирье гэвэл зурхайд хур

Хүн альяа гэвэл Манбад хур гэдэг үг байсан. 4 аймаг, Цогчэн, Манба, Зурхай, Чойр зэрэг дацангуудтай байсан. Найдаг ч гэдэг Халиар ч гэдэг ихээ том уул байгаа. Тэрний өвөрт байсан юм. Улаанбаатарын Тахирын нуруу гэдэг дээрээс Хараагийн дарь эхийн хийдийн Халиар уул харагдлаа гэж ердийн хөсгөөр явсан хүн ярьдаг байсан юм.

Домд хурах, домд мордох лам нар гэж байна. Хөдөөний малчин чинь үнэн худлыг мэдэхгүй буян санах юм гэж байгаа юм. Тэгэхээр нь нэг ядуу лам гавж болно гэнэ. Хувь хөрөнгө нь хүрэхгүй. Тэгэхээр нэг буян санасан хүн, жишээ нь манай аав бол Мишиг гэдэг хүнийг гавж болгосон. Манайд их тусална. Цагаан сараар хүртэл ирж боов хийж өгдөг байсан. Бас нэг тийм аятайхан гавж лам байсан. Баригдаад явсан. Тэгээд манайхан тэгж ярьдаг байсан. Мишигийг баригдах замд нь манайх оруулжээ гэж.

Дарь эхийн хийдийн гол шүтээн нь Дарь эх. Сүүлд нь Дарь эх лам гэдэг хүнийг халихлаар нь шарилыг нь олон хооров бор давсанд хийж, давсаа норохоор нь хаяад сольж хийгээд л байдаг. Тэгсээр байтал бүр хатсан. Дүрс хэлбэр нь хэн ч таних Дарь эх лам хэвээр тэгээд алтаар бүрж гол цогчэн дугандаа дунд нь залсан. Дарь эх лам унаган Хараагийн хүн юм байна лээ. Хүүхэд ахуй цагасаа тодорсон. Энгүй хувилгаан хүн. Маанийх гэдэг айл байсан. Маань гэж эгч нь. Хэлэмгий том бор чавганц байсан гэж хүн ярьдаг. Хараагийн дарь эх лам Бүтэд гэдэг авгайтай байсан. Бүтэд нь Цагаан үхэртийн охин гэдэг байсан. Сайхан өндөр цагаан хүүхэн байсан. Эрх ямба нь их болохоороо өнгө зүс нь сайхан болчихоод байгаа юмуу. Хүүхэд байхад харахад Бүтэд гуай шиг ч сайхан хүн байхгүй. Хүн юм уу, юу юм гэмээр. Гоё ганган ч гэж жигтэйхэн. Дарь эх лам долоон хиатай. Уг ёсондоо бол зарц нар нь. Гэхдээ зарцаа гэж хэлэхгүй. Дарь эх ламын үйлдэл бүх юмыг бүгдийг нь зэхдэг. Тийм долоон дотнын лам байна. Гэрт нь орж гардаг.

Ногоон Осор гэдэг сайн мэргэн лам байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лам нар нь хийдийн эргэн тойронд суудаг байсан. Тус тусдаа хашаа байшинтай. Бид өвөл бол нэг их очихгүй. Зун их очно. Тийм хурал боллоо, цам, майдар боллоо, гавжийн сурлага төгсөж том цайллага боллоо гэдэг. Тэр бүгдэд очиж, оролцож байсан. Гавжийн цайллаганд бол хувь хөрөнгөө нийлүүлсэн айл оролцох эрхтэй. Зундаа гүүгээ бариад айргийг нь зэхээд, лам нарт боов хийж тараана, хоол хийж идүүлнэ. Зөндөө юм ордог юм шиг байна лээ. Айраг бол үргэлж л аягална. За тэгээд манай нэг муу ах хүртэл гол дээр хоёр саальчинтай хэдэн адуутайгаа хоёр адуучинтай бүх л зун болж байсан. Манайх Дэмбэрэл гэдэг хүнийг эхлээд гавьж болгох гэж байсан. Тэр хүн нь өвчтэй хүн байсан юм гэнэ лээ. Нас барчихаад оронд нь Хүрээнээс очсон Мишиг гэдэг хүнийг ядуу хоосон ном сайтай хүн юм гэнэ тэрийг орлуулж оруулаад хоёр хүний өрийг манайх төлөөд л байсан төлөөд л байсан. Хэрэгтэй л юм байх даа гэж би заримдаа хүүхэд байхдаа боддогсон.

Хараагийн хийдэд цам жилдээ нэг л удаа гарна. 100 гаруй дүртэй. Найман улаан наймуул, Хашин хаан есүүл, Хорин нэгэн дарь эх, Буга согоо хоёр, улаан сахиус гэж дуниартсан нэг их өндөр том багтай, намбалзсан явж байгаа хөдөлж байгаа нь мэдэгдэхгүй ганцаараа гарна. Азар гэж гарна. Тэгэхэд найман улаан гэдэг бол найм л байна. Хэрээ гэдэг бол хоёр л байна. Хохимой гэдэг бол хоёр л байдаг. Улсууд тойроод зогсоно. Цамын талбайгаа тойруулаад гороо татчихсан. Шохой юм уу юу юм. Гурван давхар. Цам тэр дотроо дэглэнэ. Талбай нь том л доо. Үзэж байгаа ардууд гэдэг чинь хэдэн аймаг сумаас цуглачихсан. Газар суугаад үзнэ. Арынх нь улсууд морин дээрээсээ үзнэ. Тэгсэн урд талын улсууд ахисаар байгаад нөгөө гороон дотор шохойн зураасан дотор нь орно. Хүний хэл мэдэх биш дээ манай Монголчууд хэзээний. Нөгөөдүүлийг чинь хохимой гэдэг нэг их цагаан хувцастай, эрэн мод барьсан, тэр явж хатгана. Цашаа гэж байгаа нь тэр. Хохимойг ойртож ирэхээр ардууд энд тэнд нь хадаг хавчуулаад байна. Одоотой адилгүй л дээ. Мөнгө байхгүй. Хоёр хар хэрээ гороог хамгаалж гүйж явахдаа хар хэрээний хувцастай, тэрэнд хамаагүй хар хүн гарна. Манай ах нэг их үгэнд дуртай залуу, тэр хар хэрээнд гараад. Хэрээ хохимойны хадгийг булааж авах гэнэ. Хохимой модоороо цохиод хэртэй бол өгөхгүй. Хэрээ шонхолзож байгаад хааяа нэгийг суга татвал буцааж өгөхгүй өөрөө авна. Тэгж байтал найман улаан гэж ижил найм гарч ирж цам харайна. Хашин хаан гэж малийсан таяг маягтай ижил хувцастай дандаа жижигхэн лам хүүхдүүдтэй гарч ирнэ. Тэд наймуул Хашин хаантайгаа есүүл гарч ирнэ. Хорин нэгэн дарь эх гэж бий. Тэр цамыг Хорин нэгэн дарь эх гэж нэрлэнэ. Мөн Титэг ч гэж нэрлэнэ. Хоёр хоёроороо гарч ирээд цамаа харайгаад л байгаад байна, байгаад байна. Хорин нэгэн дарь эх бол дундаас хойш гарч ирнэ. Цам гарсны дараа сор зална. Сор залахад их сүртэй. Их гал түлээд одоо тэр Сэрэлт дээр аваачиж шатаадаг яг тэр. Нар тусахаас урд л үйлдлийнхээ багаж зэмсгийг зэхдэг байх. Бишгүүр гэж нэг их сайхан дуутай хэдэн алд урт зэмсэг байх. Тэр бүрээ бишгүүрийн дуу тасрахгүй. Цам гарсан өдөр бороо хариулдаг лам өдөржингөө л сууна. Өндөр гэгээний хийдийнхийг Хар эрэгт ловон гэж нэрлэдэг байсан. Дарь эхийн хийдийн хэнбугай нь сууж байсан юм бол доо. Сууж л байдаг байсан. Бас нэг дөрвөн хүн байна. Ерөнхий зохицуулагч нь юм байх даа. Цам өдөржин үргэлжилнэ. Бүгдээрээ гарч ирэх гэж их удна. Зарим хүн Дамдин Чойжоо шиг юм чинь яачихаа вэ хөдөлж ядаад гэж хэлдэг байсан. Гарч ирэхдээ тэгж гүйгээд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гүйгээд гарч ирдэг дүр байхгүй. Тэр хоёр гурван хохимой хүртэл өөртөө таарсан бүжигтэй. Тэрийгээ хийж гарч ирнэ. Их ганган. Тэр бүжгийг үзэх гэж л ард түмэн цугладаг байж шүү дээ. Хорин нэгэн дарь эх Титэм гэдэгт хоёр хоёроороо дандаа ижил бүжигчид байна. Хамгийн сүүлийн хоёрт толгой бөгс нь танигдахгүй савчдаг их сайн бүжигчид байна. Батаагийн Самбуу гэдэг хүн тэрний нэгэнд гардаг байсан. За одоо Самбуу гуай савчаад гарах боллоо доо гэж бид хардаг байсан юм. Хараагийн дарь эхийн хийдэд Майдар эргэдэг байсан .

Дарь эхийн хийдээс Мишиг ахыг, Галсанжамц гавж, Дамбий лам, Дандар хамба нар баригдаад явсан. Хөгшин лам нараас нэг ч эргэж ирээгүй. Дөрвөн хүн арван жилийн ял авсан. Мишиг гавж нэгэнд нь орсон. Арван жил үйлдвэрт юм оёж байгаад харьж байсан. Манайхан гэдэг чинь чамайг яав яав гээд л асуусан. Галсанжамц багш эд нар бол очоод дарагдаж үхсэн байх гэж байсан. Жижиг банди нарыг орхисон юм байна лээ. Улс эзгүй хаяагүй. Сүүлд нь Сэлэнгэд аваачаад лам 100 хүүхдийн сургууль гэж байгуулагдаад манай өвгөн захирлаар нь очиж нэг жил ажиллаад ирж байсан юм.

Хараагийн дарь эхийн хийд мод, туйпуугаар барьсан дугануудтай байсан. Дарь эх лам, үйзэн хоёрын суудаг Сэмчин нь хоёр давхар. Дарь эх ламын хүүхэн гэхгүй үйзэн гэнэ шүү дээ. Цогчэн дуган нь Өндөр гэгээний хийдийнхтэй адилхан. Бага л болохоос биш. Дээрээ сууж хурал хурна гэж байхгүй. Дан бурхан тахилын л орон сав. Цогчэн дуганын голд дарь эх ламын шарилыг байрлуулаад сүүлд нь устгал хийхэд манай сумын дарга Ядамжав гэдэг хүн Дарь эх ламын занданшуулсан шарилын чихэнд нь байсан ээмгийг мулталж авлаа гэж байсан. Дарь эх лам амьддаа чихэндээ ээмэг зүүдэг байсан. Дашдэлэг гэдэг хүүхэн авгай нь. Тэр чигээр нь зүүхээр томдоод байна гээд жижигрүүлсэн гэж дуулдсан. Лам нар баригдаж яваад устгал хийгээд нураагаад хаяхаар хуучин дуганы түлшний мод зөндөө гарсан. Сумын захиргаа зөөгөөд зөөгөөд бараагүй. Айлууд ч их зөөсөн. Миний дээд талын ах Галсанбалдан гэдэг. Хийдээс мод ачиж ирээд ээжид нөгөө Дарь эх ламын чинь хатаасан махан дарь эх ламыг чинь онхолдуулаад хаячихсан нохой зулгаагаад даахгүй байна гэж хэлсэн. Ээж чи доромжилж нохой зулгаалаа, нохойн хоол боллоо гэж ярилаа чамайг хэн яриатах гэсэн юм гэж хүүгээ зөндөө загнаж байсан юм.

Дарь эхийн хийдийн замд хонд гэж бий. Хонд нь хийдээс 15 орчим км зайтай. Айлууд нь дуган дацан дундаа бөөндөө. Лам нараа нас барахаар унаа хөсөг ч гэхгүй. Тэр хондондоо дамнаж аваачаад хаячихна. Чоно нохой ирэхийн завгүй л өөрсдийнх нь ноход очоод л идчихнэ. Би бүр идэж байхыг нь хараад ирээд унтаж чадахгүй байсан. Манайх тэр Орхон голын энэ талд нутаглаж байсан. Манайхан байсгээд л Дарь эхэд мөргөнө гээд явдаг. Дарь эхийн хийдэд зоч лам нар байгаагүй.

Манайхны тэр хавьд Номтын дуган гэж зодын тусгай хурлын газар байсан. Номт уулын энгэрт байсан. Нэг дугантай. Зөндөө олон зоч нартай. Нярав нь Энхлэр гэдэг хүн байсан. Данзан гэлэн, Балдан гэлэн, үсээ задгай тавьчихсан бүдүүн дамар барьсан авгай нар байсан. Хүүхнүүд чинь сурах гээд зэрэг балбаад л. Манайхан тийм юманд их дургүй. Манай аавыг бие нь өвдөөд байхаар тэр багш хэлсэн. Чи их нүгэлтэй хүн юм байлгүй. Том дамар бариад ном уншаад явж бай гэсэн. Аав чадахгүй

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ээ чадахгүй. Том дамар бариад үхсэн хүний хонд хэсээд явж чадахгүй гэж байсан. Бид ч аавын заншлаар тийм юманд нэг их сүжиглэдэггүй, сэжиглэдэггүй байсан. Зодын дуган бол лут их ажиллагаатай байсан. Малтай байсан. Дөрвөн зоч гараад жодгороо, тогоо шанагаа үүрээд гарна. 108 хоног гэрт орохгүй гэж явж байгаа юм. Эргээд ирэхэд нь номын тайллага гэж аюулын том юм болно. Нутгийн ардууд хонь мал, үхэр энэ тэр ч гаргачихсан цав бэлтгээд номын тайллагатай гээд нэг өдөр Номтын дуган руу наадам хийж байгаа юм шиг цувна. Өглөө цуглаад, орой тарна.

Шажин талын Мянгадарын дуган гэж байсан. Бас нэлээн том. Лав зуун лам байсан байх. Мянгадарын дуган Хушаатын бэлд Мянгадарын хошуу гэж байгаа. Тэнд байсан юм. Эгц өндөр догшин хадтай уул. Тэрийг хошуу гэдэг юм. Тэгээд хошууны дуган гэж нэрлэдэг. Мянгадарын дуганд Гомбосүрэн гэлэн гэж байсан. Жадамбынх гэдэг олон хүүтэй айл байсан байгаа юм. Хагас нь хар. Зарим нь лам. Тэднийх тэнд дандаа байдаг байсан. Нэг хүү нь Мянгадарын дуганд том лам байсан. Ганц том дугантай, тэгээд хоол ундны жижигхэн тааруухан юмнууд байсан. Одоо бол ганц гадасны нүх ч үлдээгүй айлын зуслан намаржаа болчихсон байна лээ.

Мөн Баруун энгэрийн дуган гэж хэдэн ламтай дуган байсан.

Хийдийн жасын малыг тоолох гээд хийдээс нь очихоор хатсан арьс эрээд л гүйчихнэ. За тэгээд таван хонины арьс олоод ирвэл таван хонь үхсэн гээд тоолуулчихна. Гэгээний хишгийг буруу идсэн улс гэж хэлдэг байсан. Тэр нь ч үнэн юм шиг байгаа юм. Хятадын худалдааны пүүс Дарь эхийн хийд, Амар хийд хоёрт хоёуланд нь байсан. Их баян пүүс байсан. Бас их малтай. Тоолдог эзэн нь очиход тэд үхсэн гэхээр манайх үхэлгүй яахав, манайх үхэлгүй яахав гэж байсан гэнэлээ.

Тэр үед хүмүүс маш их сүжигтэй байсан. Ер нь Өндөр гэгээний хийд орж мөргөхгүй бол тэр жилдээ амьд явах насгүй гэж боддог байсан байх шүү. Зарим нь мориор, зарим нь үхэр тэрэг хөллөж цохиж нүдсээр байгаад л очдог байсан. Өндөр богдод мөргөнө гээд Хүрээний лам нар хавчиг үүрэг үүрээд л гүйж явна. Манайхнаар орж цай унд уугаад л гардаг байсан. Ерөөгийн буриад нар бол дөрвөн дугуйтай тэрэг, хоёр дугуйтай тэргээр их ирдэг байсан. Дээр үеийн хүмүүс илүү их сүжигтэй байсан гэж боддог. Миний наяд гарч нас барсан ээж Далай лам Монголд, Ганданд ирэхэд надад хэлж аваачсангүй, би мөргөж чадахгүй ч гэсэн салхиных нь доогуур явах байсан юм гэж уйлж байсан юм. Би өөрөө тэгж санаагүй байсан.

Хараагийн дарь эх ламыг тэр чигээрээ л их шүтдэг байсан. Сүүлд Дандар хамбыг бол Дандар хамба гуай явж байна гээд л бодоод өнгөрдөг байсан. Дарь эх лам шиг шүтдэггүй байсан. Дарь эх лам хорь хүрээгүй залуу байсан. Гэр нь Нарсан сүүлт гэдэг газар нутагладаг байсан. Дарь эх ламыг модонд яв гээд явуулдаг. Хэдэн үхэр тэрэг хэлхэж хөтлөөд явдаг. Дорхноо л мод ачаад ирдэг юм гэнэ. Энэ одоо нэг тэргэнд л мод ачсан юм шиг хүрээд ирэх юм ямар учиртай юм гээд алсаас харахад нарсан дотор ороод тэргээ тавихад хэдэн грушиг гараад л ачаалаад өгч байх юм гэнэ. Тийм шидтэй байхыг нь сүүлд мэдсэн гэдэг. Тэгээд ялгаж залсан юм байна лээ. Малд явж ирэхэд нь модон хувинтай тараг өгчээ. Таргаа дуусгачихаад хувинг нь малтаад байсан юм байх. Хувингаа эргүүлээд долоочхооч гэж л дээ. Тэгсэн модон хувинг эргүүлчихсэн долоож байсан юм гэнэлээ. Гутлаа тайлаад

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

унтаж байхад нь хөлийнх нь улан дээр бурханы нүд шиг нүд харагдаж байсан. Тэгээд л энийг чинь муучилж болохгүй хүн байна гэж мэдсэн гэсэн. Өөрөө нэг нэртэй. Нэрээ ер нь хэлэхгүй. Засаг нэг хүн амаа тоолоод нэр усаар нь бүртгэхэд та нэрээ айлдаач гэхээр хүн гээд биччихгүй юу гэсэн. Тэгвэл Дарь эх лам гээд биччих үү? гэхээр өөрсдөө мэдэхгүй юу гэж хэлж байсан гэсэн. Нэг удаа морин тэрэгтэй дээр нь авгайгаа суулгачихсан явж байгаад зуслангийн айлуудын гадаа тэргээ зогсоочихсон хиа нартайгаа хонох гэж байхад нь ойртож очиж нэг мөргөсөн. Бор шар дээлтэй, хуучин шляпэн малгай базаад өмсчихсөн. Савхин гуталтай байсан байх. Дарь эхийн хийд дээр тодорч ирэхдээ за Буриад-Оросын нутгаар явна аа гээд морин тэрэгтэй, хэдэн хиа нартайгаа явжээ. Намайг нэг хэсүүчилсэн юм явна л гэж бодож байгаа байх даа. Атга арвай аваад цацахад гал болоход эднүүд намайг юу гэж санах болоо гэж. Нэг дотно хүн нь та тэгээч гэсэн. Тэгээд хаясан гал болоод унаж байсан гэсэн. Тэгсэн тэр буриадууд орой дээрээ залбираад үсэрч унаад байсан гэсэн. Цаашаа Оросын нутаг руу явсан. Буриадуудаас хүн дагаж яваад энэ их идтэй шидтэй хүн гэхэд, хил давж оруулахад шалгана гэжээ. Хүйтэн хооров шиг юманд хийгээд хүйтнээр үлээлгээд хөлдөх нь үү гээд үзсэнд хөлс нь гарчихсан яасан халуун юм бэ гээд гарч ирж байсан. Халуунд хийсэн сахал нь цантсан гарч ирж байсан гэж ярьдаг. Тэгж явж байхдаа индүү болон бусад техникийн зүйлс авч ирж ашиглаж хэрэглэж байсан. Өөрөө дарх хийдэг байсан. Сүүлдээ эрх тушаал нь ихдээд тэгэхээ больсон гэдэг.